

**ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН.**

2025.12.10.

Д/д	АРГА ХЭМЖЭЭ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	БИЕЛЭЛТ
	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд			
	1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжит хэлбэрээр нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчид болон олон нийтэд сурталчилж байх;	Баримтжуулсан байх Үр дүнг тооцож, Тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)	Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан “Авлигын эсрэг хуулиас”, “Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд хориглоно”, “Авлигын хэлбэрүүд”, “Авлигын эсрэг таны оролцоо” “Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт”, Бэлэг үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд” гэсэн 6 төрлийн постер, Нийгмийн даатгалын ерөнхий газраас бэлтгэсэн гаргасан 2 төрлийн постерийг тодорхой хугацааны давтамжтай байгууллагын веб сайтад байршуулан олон нийтэд түгээв.	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжит хэлбэрээр нийгмийн даатгалын албан хаагчид болон олон нийтэд сурталчилж Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нэртэй пэйж хуудсаар тухай бүр түгээж ажиллаж байна. Нийт 56 удаа түгээсэн байна.
	1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	-2-с доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас 9 дүгээр сарыг “Нээлттэй мэдээллийн сар” болгон зарласантай холбоотой 2024 оны 9 дүгээр сарын 20-ний өдөр ажил олгогч, иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөн туслах, хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор “Нээлттэй хаалганы	1. Бор-өндөр УБҮ-н ажлын байранд Татвар, ХХҮГазартай хамтран 2025.05.07нд “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулсан. УБҮ-ын ажилтан албан хаагчдад ажлын байран дээр нь төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажилласан бөгөөд тус өдөрлөгийн хүрээнд УБҮ-ын 129-н даатгуулагчид нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулсан.

		өдөрлөг”, “Явуулын үйлчилгээ”-г зохион байгуулж, нийгмийн даатгалын үйлчилгээг сурталчлав.	Мөн 2 тэтгэвэр авагчийн ажилласан жилийн нэмэгдэл хийлгэх материал хүлээн авч, архивын лавлагаа захиалах 1 иргэний материалыг тус тус хүлээн авсан. Нийт үйлчилгээ авсан ажилчдад тэтгэвэр, тэтгэмжийн талаарх асуултад хариулт өгч зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан. 2. 2025 оны 09 дүгээр сарын 26-нд Аймгийн ИТХ-с зохион байгуулсан төрийн үйлчилгээг иргэд байгууллагад ил тод хүргэх, тайлагнах зорилгоор “Иргэдийн өдөр” өдөрлөгт оролцож нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчилж, иргэдэд гарын авлага, танилцуулга тарааж ажилсан. 3. Иргэд, даатгуулагч, малчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөн туслах зорилгоор 21 сумын 88 багийн 6934 иргэд малчдад “Явуулын үйлчилгээ”-г хүргэн сайн дурын даатгалын ач холбогдлыг сурталчлан, малчин тэтгэврийн болзол нөхцөлийн талаар мэдээлэл өгч ажилласан.
	Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх		Сумдын нийгмийн даатгалын байцаагчидтай хамтран Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2 рийл контент бүтээж байгууллагынхаа пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн.

	1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарын мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол ажиллуулах;	-Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	Нийгмийн даатгалын газрын мэдээллийн самбарт Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, түүнийг мэдээлэх талаар уриа, Авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх “110 дугаар”-ыг, санал хүсэлтийн хайрцгийг байршуулан ажилласан.	"Шударга ёс, хөгжил дэвшилд" самбарыг тогтмол ажиллуулж Нийгмийн даатгалын газрын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр байршуулж авлигын эсрэг мэдээ, мэдээлэл, санал хүсэлт, өргөдөл гомдлын хайрцгийг байнга байршуулан ажиллаж байна. Өргөдөл гомдлын хайрцагт санал хүсэлт ирээгүй болно.
	1.4.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон бусад нийт албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх.	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон бусад нийт албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх. -Тайланд нотломжийн хамруулсан байх.	Ажилтан, албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр нийт 5 сургалтад давхардсан тоогоор 120 албан хаагчдыг хамруулсан. 2024 онд авлига, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон албан хаагч байхгүй болно.	Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 1 удаа зохион байгуулж НДЕГазар болон АЗДТГазраас зохион байгуулж байгаа "Нэг цаг, нэмэх цэнэг" сургалтад цахимаар 5 удаа хамрагдаж нийт давхардсан тоогоор 116 албан хаагч хамрагдсан. 2025.05.08-нд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орон нутагт ажиллаж амьдрах эрхийн баталгааг хангахад анхаарах асуудлыг тодорхойлох” сэдэвт сургалтыг хууль зүйн доктор, профессор Б.Өлзийсайхан 23 байцаагч хамрагдсан. 2025.05.15-нд “Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх,” сэдэвт сургалтыг хууль зүйн доктор, профессор Б.Өлзийсайхан 25 байцаагч хамрагдсан. 2025.07.04-нд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ сэдвээр НДЕГ-ын ёс зүйн дэд хорооноос сургалт зохион байгуулсан 31 албан хаагч хамрагдсан. 2025-06-04 НДЕГ-с Төрийн алба

				хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ сэдэвт сургалтад ёс зүйн дэд хорооны 5 гишүүд бүрэн хамрагдсан. 2025-11-17-нд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иар НДЕГ-н Захиргаа удирдлагын газрын ахлах мэргэжилтэн М.Гэрэлмээ хичээл орсон ба үүнд 32 албан хаагчийг цахимаар хамруулсан.
	1.5.Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн магадлалын төв болон салбар зөвлөлийн эмч, мэргэжилтнүүдэд 2-с доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна.	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогч талууд нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шийдвэрлэхдээ авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт цахим сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулав. Тус сургалтаар комиссар Г.Ундармаа авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэг сэдвээр хичээл заан мэдээлэл хийж, оролцогчдын асуултад хариулт өгч санал солилцов.	“Даатгуулагч, иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай”, “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-ын талаарх сургалтыг тэтгэмжийн байцаагч Б.Алтансүвдтай хамтран 2025 оны 02 дугаар сарын 5-14-ны өдрүүдэд танхимаар болон цахимаар 2 удаа зохион байгуулсан. Сургалтад нийт 70 эмч ажилчид хамрагдсан. ЭММТЗөвлөлөөс, АТГазрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн талаарх ээлжит сургалтад 2025-05-28-нд цахимаар оролцож 5 эмч, 3 мэргэжилтэн хамруулсан. 2025 оны 5 дугаар сард Магадлагч эмч нарын зөвлөгөөнд хамрагдаж Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад 3 эмч, мэргэжилтэн хамрагдсан.
	1.6.Эрх бүхий байгууллагаас	Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн		Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн дүрэм, журмын төслийн санал ирээгүй.

	ирүүлсэн дүрэм, журмын төсөлд санал боловсруулан хүргэх	дүрэм, журмын төсөлд санал өгч ажилласан байна.		
	1.7.Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар албан хаагч, олон нийтэд сурталчлах.	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор албан хаагч, олон нийтэд мэдээлэл өгөх, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар таниулсан байна.		Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор албан хаагчдад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ёс зүйн зөрчил болон шударга бус үйлдлийн талаар шүгэл үлээхийг байгууллагын хурал дээр тогтмол уриалж сануулдаг. Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал гаргасан, ямар нэгэн үйлчилгээ үзүүлний хөлсөнд шан харамж нэхсэн үйлдэлийг байцаагч албан хаагч гаргасан бол шүгэл үлээхийг сургалт, сурталчилгаа хийх болгонд уриалж сануулан ажиллаж байна.
	1.8.Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад гарсан аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх.	-Магадлагч эмч, мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад гарсан аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига,ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх арга хэмжээг тусгах. Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих, хяналт тавих		Эрүүл мэндийн магадлалын зөвлөл тайлант хугацаанд 42 удаа хуралдаж, 1556 иргэн, даатгуулагчийн хувь хугацааг тогтоож, хяналтын үзлэг шинжилгээнд хамруулсан Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд болон ХБИргэдын хувь хугацаа тогтоох сунгах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх асуудлыг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй хуулийн хүрээнд, үнэн зөв шийдвэрлэж мөн ХЧАлдалтыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шинэчлэгдсэн журмын дагуу хүнд өвчтөнийг цахимаар, бичиг баримт видео бичлэгийг үндэслэн орон нутагт нь ХЧАлдалтыг тогтоож ажиллаж байна. Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад гарсан аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига,ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх арга хэмжээг

		боломж тавих.		Магадлагч эмчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр оруулж баталгаажуулсан. Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад авлига, ашиг сонирхлын зөрчил одоогоор илрээгүй байна.
Ил тод байдлыг сайжруулах хүнд суртал, чирэгдэл бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд				
	2.1.Нийгмийн даатгалын байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага хооронд байгуулж буй аливаа гэрээ, хэлэлцээрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар зохицуулалт тусгах.	Гэрээ, хэлэлцээрт авлигаас ангид байх, мэдээлэх, үүргийг тусгасан байх.	2024 онд Нийгмийн даатгалын байгууллага нийт 7 гэрээнд “Талууд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх” гэсэн заалтыг тусган байгуулсан бөгөөд тайлант хугацаанд уг заалтыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гараагүй болно.	Нийгмийн даатгалын үйл ажиллагааг жигд ханган ажиллах зорилгоор Иргэн, Аж, ахуй нэгж, байгууллагатай ажил гүйцэтгэх, хамтран ажиллах нийт 7 гэрээг Иргэний хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хуулийг удирдлага болгон байгуулсан. Тайлант хугацаанд зүйл заалтыг зөрчсөн үйлдэл гараагүй болно.
	2.2.Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	- Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор хуульд заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах; - Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж гаргах;	Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу 2024 оны 11 дүгээр сарын байдлаар үнэлэхэд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудын дундаж үнэлгээ 81.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Шил ажиллагаа (shilen.gov.mn) цахим хуудаст Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд нийт 1,343 мэдээлэл илгээснээс 938 зөв мэдээлэл илгээсэн байна.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгууллагын веб сайтад чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын мэдээ, мэдээллүүдийг тухай бүр байршуулсан. Шил ажиллагааны shilen.gov.mn-д 2025 оны 1 дүгээр улирлын тайланг 2025.02.24-ний өдөр илгээж 94.3 , 2 дугаар улирлын тайланг 2025.06.28 нд илгээж 97,5 , оны 3 дугаар улирлын тайланг

				2025.09.29-ний өдөр илгээж 93.4 хувийн үнэлгээ авсан.
	2.3.Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар олон нийтэд ил тод байршуулах, төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагч нарын ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой болгох нэр тус бүрээр ил тод, тодорхой мэдээлэх.	Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар олон нийтэд ил тод байршуулах, төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагч нарын ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой болгох нэр тус бүрээр ил тод, тодорхой мэдээлсэн байна.	Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар олон нийтэд харуулах тусгах арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны батлагдсан төсөв, 2025 оны төсвийн төсөл, төсөөллийг шилэн дансанд нээлттэй, ил тод байршуулан ажиллав.	Shilendans.gov.mn цахим хуудсанд Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар, Нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны батлагдсан төсөв болон бусад байршуулах мэдээллийг тухай бүрд оруулсан. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар НДЕГазрын ДАМГазраас хяналт шалгалт хийсэн ба байршуулсан мэдээллийн байдал 100 хувь, хугацаандаа мэдээ байршуулсан байдал 91 хувьтай дүгнэгдэж, цаашид анхаарах асуудал байхгүй дүгнэлт авсан. Оны эхнээс нийтдээ Shilendans.gov.mn цахим хуудсанд 81 мэдээллийг хугацаа хоцролтгүй хугацаанд нь байршуулан ажиллаа.
	2.4.Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, Ёс зүйн дэд хороо, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, маргаан таслах үйл ажиллагааг сайжруулах, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх.	Маргаан шийдвэрлэх хугацаа буурсан байна.	Засгийн газрын 2023 оны 362 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм”-ийн 4.4-т “Төв болон салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга гомдол, хүсэлтийг хүлээн авч ажлын нэг өдөрт багтаан бүртгэж, тухайн зөвлөлийн даргад тухай бүр хүргүүлэх бөгөөд төв болон салбар зөвлөл нь уг дүрмийн 4.5-д заасны дагуу буцааснаас бусад тохиолдолд гомдол, хүсэлтийг 30 хоногт багтаан хянаж	Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл 2025 оны байдлаар нийт 15 хүний өргөдөлөөр 5 удаа хуралдаж 12 хүний нөхцөл хангасан шийдвэр, 3 хүний малчин жил болон газрын дор нөхцөлөөр ажилласан жил тогтоох боломжгүй гэсэн шийдвэр гарсан байна. Ёс зүйн дэд хороонд 3 албан хаагчтай холбоотой өргөдөл, гомдол иргэдээс ирүүлсэний дагуу хуралдаж 2 өргөдөлд дүгнэлт гарган эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн, 1 өргөдөл нь манай ёс зүйн хороонд хамааралгүй тул буцаасан. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн

			шийдвэрлэнэ" гэж заасан хугацаагаар шийдвэрлэсэн.	үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол ирээгүй болно.
	Авлига ашиг сонирхлын зөрчил үүсэх, шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах зорилгын хүрээнд			
	3.1.Тухайн жилд Нийгмийн даатгалын байгууллагаас авлига ашиг сонирхлын зөрчил үүсэн тухай эрх бүхий байгууллагаас шаардлага хүргүүлсэн, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн, үүссэн байж болзошгүй тохиолдолд зөрчлийг таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах.	-Нийгмийн даатгалын байгууллагаас авлига ашиг сонирхлын зөрчил үүсэн тухай эрх бүхий байгууллагаас шаардлага хүргүүлсэн тохиолдолд тухайн Зөрчил гаргасан нэгжид тухайлан арга хэмжээ авах, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилган эрх бүхий байгууллагад тайлагнасан байна. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин дахь нийгмийн даатгалын байгууллагын авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой, олон нийтийн анхаарал татсан мэдээллийн мөрөөр хуульд заасан арга хэмжээ авсан байх.		2025 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Бор-Өндөр сумын Нийгмийн даатгалын тасгийн 2022-2024 оны тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтонд хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтаар ажилгүйдлийн даатгалын сангаас 35,7 сая төгрөгийг зориулалт бусаар ашигласан зөрчил илэрч улсын байцаагчийн акт тогтоосон. Мөн 2025 оны 12 дугаар сарын 04-нд НДЕГазарт албан тоотоор мэдэгдсэний дагуу НДЕГазар Авлигатай тэмцэх газарт шалгуулах албан бичиг хүргүүлсэн.
	3.2. Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах.	-Нийгмийн даатгалын байгууллагын “Шударга байдлын үнэлгээ”-г 80 хувьд хүргэсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Төлөвлөгөө батлах тухай”А/48 дугаар тушаалаар “Шударга байдлын үнэлгээг сайжруулах 2024 оны арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан салбарын	Байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шахалт үзүүлж нөлөөлөх байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автах явдал, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал, бусдаас нэмэлт төлбөр, бэлэг хандив, санхүүгийн тусламж авах явдал, хууль тогтоомжоор олгогдсон

			хэмжээнд хэрэгжилтийг зохион байгуулав. Уг төлөвлөгөөг “Гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах” чиглэлээр 8 арга хэмжээ, “Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах” чиглэлээр 2 арга хэмжээ, “Бодлогод оролцогчдын үнэлгээг сайжруулах” чиглэлээр 1 арга хэмжээг тусган төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж Авлигатай тэмцэх газарт хагас, бүтэн жилээр тус тус биелэлтийг хүргүүлэн 74.5%-тай үнэлэгдсэн.	бүрэн эрхээс илүү эрх эдлэх, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх, албаны мэдээллийг хувийн зориулалтаар ашиглах эсхүл бусдад дамжуулах зэрэг үйлдлийг дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцох байдлыг сайжруулан төрийн жинхэнэ албан хаагчтай хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн үйлчлүүлэгч албан хаагчид ил тод үнэлгээ өгөх төхөөрөмжийг суурилуулан бичлэг хийж, үнэлгээ өгүүлэн ажиллаж хэвшсэн. Бичлэгийг шаардлага гарсан тохиолдолд үнэлгээний төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн үзэж маргааныг шийдвэрлэх эрхтэй ажилладаг.
	3.3.Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрэм нь авлига, ашиг сонирхлын зөрчил гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал хүргүүлэх, өөрийн байгууллагын гаргасан тушаал шийдвэрт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох.	-Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журам нь авлига, ашиг сонирхлын зөрчил гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал хүргүүлэх, өөрийн байгууллагын гаргасан тушаал шийдвэрт өөрчлөлт оруулах, хүчингүй болгосон байна. -Шийдвэр, дүрэм, журам хүчингүй болгосон		Тайлант хугацаанд удирдах албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэрт авлига, ашиг сонирхлын зөрчил гарч болзошгүй нөхцөл боломж бүрдүүлсэн зүйл гараагүй болно.

		талаарх хүргүүлсэн санал, нотолгоог хүргүүлсэн байна.		
--	--	---	--	--

ТАЙЛАН БИЧСЭН / А.ОКТЯБРЬ/

Мэдээлэл лавлах албан хаагч:

НЭР	АЛБАН ТУШААЛ	ЦАХИМ ШУУДАН	УТАС	ӨРӨӨНИЙ №
А.ОКТЯБРЬ	Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга	88906919	nanjidmaa.e@ndaatgal.mn	204